

## SANDBOX



### ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5–8 Зохицуулалтын мэдээ
- 9–11 Байр суурь
- 12 Ногоон финтек
- 13–14 Сэндбокс зохицуулалтын орчны хөгжил, дэвшил
- 15–22 Сэндбокс зохицуулалтын журмын олон улсын харьцуулсан судалгаа
- 23–24 Санхүүгийн боловсрол
- 25–26 Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбоксын орчинд цаг алдахгүй турших нь
- 27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах индекс

## ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ



Энэ удаагийн ярилцлагаар сэндбокс зохицуулалтын орчны өнөөгийн байдлын талаар Сэндбоксын зөвлөлийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуунтай ярилцлаа.

**Сайн байна уу, танд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын санхүүгийн зах зээлд Сэндбокс зохицуулалт нэвтрээд жил гаруйн хугацаа өнгөрсөн байна. Тус зохицуулалтын үр ашиг, ач холбогдлын талаар энэ удаагийн ярилцлагаа эхэлье.**

Технологийн хурдтай өөрчлөлтийн нөлөөгөөр санхүүгийн зах зээл хувьсан өөрчлөгдөж, урьд өмнө нь зохицуулалтад байгаагүй шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрэх, мөн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ салбар дамнан хөгжиж өөр, хооронд нь ангилан ялгахад хүндрэлтэй болсон зэргээс шалтгаалан зохицуулалтын давхардал, хийдэл үүсэх зэргээр санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын орчинд холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлага үүсээд байгаа юм.

Хууль, эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт нь технологийн нөлөөгөөр санхүүгийн зах зээлд өрнөж буй хөгжлөөс хоцордог учраас зохицуулалт, хяналтын хоцрогдол бий болох мөн зах зээлийн хөгжлийг хязгаарлаж, удаашруулах зэрэг эрсдэлүүд үүсдэг. Уг хоцрогдлыг арилгах, технологид суурилсан санхүүгийн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон зохицуулалтын орчин нь бүрдэх хүртэлх хугацааг нөхөх зорилгоор анх сэндбокс зохицуулалт үүссэн.

Нөгөөтээгүүр уг технологийн шинэчлэлт, өөрчлөлтөд тохирсон зохицуулалтыг оновчтой бүрдүүлэхэд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээнд туршин, зах зээлд амьдрах чадвар, үүсэж болзошгүй эрсдэл зэргийг нь урьдчилан таньж мэдэх нь чухал ач холбогдолтой учраас сэндбокс зохицуулалт нь өнөөдөр олон улсад бодлогын оновчтой шийдэл болж байна. Мөн сэндбокс зохицуулалт нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг турших, тэдгээрт тохирсон зохицуулалтын орчныг бүрдүүлэхээс гадна санхүүгийн зах зээлийн хөгжлийн хурд, чиг хандлагыг харах цонх нь болж байна.

Үргэлжлэлийг 9-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### СЭНДБОКС

Сэндбокс гэдэг нь технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг санхүүгийн зах зээлд нэвтрэхийг дэмжих зорилгоор зохицуулагч байгууллагын хяналт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгодог зохицуулалтын арга хэрэгсэл юм.



### SANDBOX

Sandbox is a regulatory tool that allows innovative products, services and business models to be tested in a limited environment and time, under the supervision and regulation of the financial supervisory authorities.

*Эх сурвалж: Сэндбокс зохицуулалтын орчны журам*



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хүн төрөлхтөн санхүүгийн зах зээл, технологийн хослолын үр ашгийг хүртэж эхлээд хэдэн арванаар тоологдох цаг хугацаа өнгөрч байна. Технологид суурилсан санхүүгийн зах зээл буюу финтекийн хөгжлийн түүх 1886 оноос эхэлсэн гэж тэмдэглэгддэг ч өнөөгийн бидний хэрэглэж дадсан механик үйлдэл багатай, автоматжсан санхүүгийн зах зээлийн хөгжил 50 гаруй жилийн өмнөөс эрчимжсэн.

1970–аад оноос эхэлсэн өгөгдлийн шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил нь санхүүгийн байгууллагуудыг өөрсдийн хэрэглэгчид, үйлчилгээний өртөг, ашгийн шинжилгээг гүйцэтгэх боломжийг олгосноор санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, мөнгөн урсгалын гүйлгээ улам бүр эрчимжихэд нөлөөлсөн. Түүнчлэн санхүүгийн байгууллагууд нэгэн ижил стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлснээр санхүүгийн зах зээлийн интеграцлал хурдтай өрнөж эхэлсэн. Тухайлбал бид бүгдийн ашиглаж хэвшсэн SWIFT сүлжээ нь уг стандартчилалд суурилан анх үүсэж хөгжиж байсан түүхтэй.

Үүний дараагаар интернэтийн эрин үе эхэлснээр бусад олон салбарын адил санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлтүүдийг авчирсан. Интернэтэд суурилсан уг хувьсгал нь өөрөө дараа дараагийн хөгжлийн шинэ үе шатыг авчирсан бөгөөд эдгээрийн нэг нь 2000 оноос

эхлэн бидний өдөр тутмын амьдралд хүчтэй нөлөө үзүүлж ирсэн гар утас, ухаалаг утасны хэрэглээ юм. Гар утасны хэрэглээн дээр суурилсан олон нийтийн сүлжээний хэрэглээ нэмэгдсэн бөгөөд өнөө цагт бид олон нийтийн сүлжээг зөвхөн хэн нэгэнтэй харилцах зорилгоор бус санхүү, төлбөр тооцооны үйлчилгээг авахдаа ашиглаж байна.

Санхүүгийн зах зээл нь техник, технологийг ашиглан хөгжиж буй нэг төрлийн хэрэглэгч нь мэт ойлгогддог хэдий ч технологийн хөгжил ч мөн санхүүгийн зах зээлд түшиглэн хөгжиж ирсэн. Харин сүүлийн жилүүдэд технологи болон санхүүгийн зах зээлийн хоршил нь нэлээдгүй хурдтай өрнөж буй бөгөөд технологийн дэвшил нь санхүүгийн зах зээлийн дотоод үр ашгийг нэмэгдүүлэн, зардлыг бууруулж, хамрах хүрээг өргөжүүлэн, хэрэглэгч төвтэй санхүүгийн үйлчилгээнүүдийг үүсгэн, зах зээлд олон тооны шинэ оролцогчдыг татан оролцуулж эхэлсэн. Уг технологийн хөгжил, шинэ эриний тренд цаашид ч хурдацтай өрнөн үргэлжлэх нь гарцаагүй бөгөөд ирэх жилүүдэд дараах тренд санхүүгийн зах зээлд давамгайлах байдал ажиглагдаж байна.

**Зайнаас ажиллах, зайнаас үйлчилгээгээ үзүүлэх /remote working/**

Санхүүгийн салбар нь хамгийн өндөр ачаалалтай салбаруудын нэгт багтан



тус салбарын мэргэжилтнүүд завгүй амьдралын хэв маягаараа имиж бүрдүүлсээр ирсэн. Харин сүүлийн жилүүдэд Ковид-19 цар тахлын нөлөө болон хүмүүсийн амьдралын хэв маягийн өөрчлөлтөөс

шалтгаалан зайнаас ажиллах тренд дэлгэрч буй бөгөөд ажил, амьдралын балансын асуудал хурцаар хөндөгдөх болсон. Санхүүгийн зах зээлийн хувьд ч мөн ямар нэгэн салбар, оффисгүй, өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зуун хувь цахим хэлбэрээр хүргэн, зайнаас ажилладаг банк, санхүүгийн байгууллагууд дэлгэрч байна.

### Өөртөө үйлчлэх /self-servicing/



Хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээг авахтай холбоотой бүхий л төрлийн үйлдлээ хэн нэгэн ажилтны тусламжгүйгээр өөрөө бие даан гүйцэтгэх чиг хандлага сүүлийн 20

гаруй жилийн хугацаанд хурдтай дэлгэрч байна. Цахим технологийн нөлөөгөөр хэрэглэгчид өөрсдийн хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ямар нэгэн хугацааны хязгаарлалтгүйгээр 24 цагийн аль дуртай үедээ ашиглаж байх хүсэлтэй болсон. Мэдээжийн хэрэг өөртөө үйлчлэх хэлбэрийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд санхүүгийн байгууллагууд технологи, сүлжээний асуудлаа бүрэн шийдвэрлэсэн байх шаардлага үүсэхээс гадна санхүүгийн салбарын стандартчиллыг сайжруулах, салбарын оролцогчдын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг улам бүр нэмэгдүүлэх болсон.


### Машин сургалт /machine learning/



Машин сургалт нь компьютерын систем ямар нэгэн тусгайлсан програмчлал шаардалгүйгээр өгөгдлийн сан дээрээ суурилан өөрөө суралцаж, цаашид

хөгжүүлэгдэж байдаг процессыг хэлдэг. Машин сургалт нь өгөгдлийн сан нэмэгдэх тухай бүр шинэчлэгдэн, хөгжүүлэгдэж, зарим тохиолдолд хүний ажиглаж чадахгүй зүй тогтол, харилцаа, хамаарлыг өргөн хүрээнд тооцож ажилладаг гэдгээрээ давуу талтай. Машин сургалт нь санхүүгийн зах зээл дэх мөнгө угаах болон залилангийн үйл ажиллагааг илрүүлэх, даатгалын салбар дахь эрсдэл, хураамжийн дүнг тооцох, хэрэглэгчийн зан төлөвийг ойлгох зэрэг үйл ажиллагаанд голчлон ашиглагдаж байна.


### Роботик процесс автоматжуулалт /robotic process automation/



Роботик процесс автоматжуулалт нь роботик программ хангамжийг ашиглан хүний үйл хөдлөлийг орлохуйц хэмжээнд хүрч хөгжиж байна. Энэхүү технологийг ашиглан

хөгжүүлсэн ботууд нь текст мэдээлэл бэлтгэх, ажлын хавтас үүсгэх, файл хуулах, цахим шуудан явуулах зэрэг үйлдлүүдийг гүйцэтгэдэг бөгөөд хүнтэй харьцуулахад харьцангуй хурдан, хямд өртгөөр ажилладагаараа давуу талтайгаас гадна механик үйлдлээс гардаг алдааг бууруулдаг. Роботик процесс автоматжуулалт нь банк, санхүүгийн байгууллагуудын тайлангийн нэгтгэлийг гүйцэтгэх, хэрэглэгчийн үйлчилгээнд ашиглагдах, тоон мэдээлэл цуглуулах, анализ хийх, данс нээх, хаах болон хэрэглэгчийг таних, арилжаа болон шилжүүлэг гүйцэтгэх, бичиг баримт боловсруулах зэрэг олон төрлөөр ашиглагдан хүний үйл ажиллагааг хөнгөвчилж байна.

### Юмсын интернэт /internet of things/



Бидний өдөр тутамд ашиглагддаг биет объектууд интернэтэд холбогдон алсын зайнаас удирдагдах болсон ойлголтыг бид юмсын интернэт гэж нэрлэдэг бөгөөд сүүлийн үед тренд болж буй “ухаалаг гэр” гэсэн нэршил нь юмсын интернэтийн нэгэн жишээ юм. Хэдийгээр юмсын интернэтийн санхүүгийн зах зээл дэх ашиглалт нь харьцангуй бага байгаа хэдий ч банк, санхүүгийн байгууллагууд өөрсдийн салбар оффис болон АТМ-ийн ачааллыг хянах, мэдээлэл цуглуулан үйл ажиллагаа, нөөцөө төлөвлөх, хэрэглэгчдийн ашиглаж буй ухаалаг төхөөрөмжүүдээс мэдээлэл цуглуулах байдлаар хэрэглэгчийн зан төлөвт суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, мөн санхүүгийн залилан, луйврын гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг байдлаар түгээмэл ашиглагдаж байна.

### Эх хэлний боловсруулалт /natural language processing/



Хиймэл оюун ухааны нэг бүрдэл хэсэг болох эх хэлний боловсруулалт нь бүхий л төрлийн аман болон бичгийн хэлбэрийн харилцаанаас хүний хэлний

мэдээллийг цуглуулан боловсруулалт хийдэг технологи юм. Эх хэлний боловсруулалт нь хэрэглэгчийн дуудлага эсхүл

цахим текст хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг шинжлэн хэрэглэгчдэд тулгарсан асуудлыг тодорхойлох замаар хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах, гэмт хэрэг болон залилангийн шинж чанартай үйл ажиллагааг илрүүлэх, бичгэн болон дуун өгөгдлөөс мэдээлэл цуглуулах байдлаар бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, судалгаа шинжилгээнд ашиглагдах зэргээр санхүүгийн зах зээлд хэрэглэгдэж байна.

### Цахим мөнгө /digital currency/



Цахим мөнгөний хэрэглээ их, бага хэмжээгээр аль хэдийн бидний өдөр тутмын амьдралд нэвтэрсэн хэдий ч цахим мөнгөнд хандах хүмүүсийн хандлага янз бүр байна. Цахим мөнгө нь төв банкнаас гаргасан цахим мөнгө

болон хувийн хэвшлийн оролцогчдын гаргаж буй цахим мөнгө гэсэн нийтлэг 2 төрөлд ангилагддаг. Өнөөгийн байдлаар цөөн тооны улс орнууд төв банкны цахим мөнгийг нэвтрүүлсэн бөгөөд дэлхийн маш олон оронд цахим мөнгийг нэвтрүүлэх тухай судалгаа, шинжилгээ, туршилт өрнөж байна.

### Үүлэн тооцоолол /cloud computing/



2020 онд IBM компаниас хийсэн судалгаагаар банк, санхүүгийн байгууллагуудын 91 хувь нь үүлэн тооцоолол ашигладаг гэсэн үзүүлэлт нь 2017 оноос хойш даруй 2 дахин нэмэгдсэн дүн юм. Сүүлийн жилүүдэд компаниуд өөрсдийн дата төвөө үүлэн технологид байршуулах болсон. Түүнчлэн олон байгууллагууд үүлэн технологийг ашиглаж эхэлсэн нь санхүүгийн зах зээл дээрх аливаа төрлийн тооцооллыг үүлэн технологи ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлж эхэлсэн.

### Их өгөгдөл /big data/



Их өгөгдөл, үүлэн тооцоолол болон машин сургалт нь нэг нэгнээсээ харилцан хамааралтайгаар хөгжиж буй технологиуд юм. Их өгөгдлийн тусламжтайгаар санхүүгийн

байгууллагууд зах зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор хянан, шинжилж, шийдвэр гаргалтдаа шууд ашиглах боломж бүрдсэнээс гадна эрсдэлийн үнэлгээ, санхүүгийн залилан, луйврыг илрүүлэх зэргээр санхүүгийн үйлчилгээний чанарыг сайжруулан, санхүүгийн байгууллагуудын үр ашгийг нэмэгдүүлж байна.

### Ногоон тооцоолол /green computing/



Уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдолтой тэмцэхэд санхүүгийн байгууллагуудын үүрэг, оролцоо ихээхэн гадна тус салбар ногоон ирээдүйд чиглэсэн олон тооны

бодлого, стратегиудыг боловсруулан, хэрэгжүүлэх болсон. Тийм ч учраас санхүүгийн байгууллагууд энерги бага зарцуулдаг, байгаль орчинд ээлтэй, дахин боловсруулагдсан материалаар хийгдсэн программ хангамж, технологийн хэрэгслүүдийг ашиглахыг эрмэлзэх болсон бөгөөд байгаль орчинд ээлтэй технологийн шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх уг процессыг ногоон тооцоолол гэж ойлгож болно.

Саяхныг хүртэл бид санхүүгийн технологийг дулаахан гэртээ, аягатай халуун цайгаа барин суугаад шаардлагатай санхүүгийн үйлчилгээгээ орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хүлээн авах боломж гэж ойлгож ирсэн ч зах зээлийн өөрчлөлт, хөгжил энэ тодорхойлолтыг энгийн нэг хэвшмэл үзэгдэл болтол нь хурдтай өрнөж байна. Технологид суурилсан санхүүгийн зах зээл бидэнд хэн нэгэн дундын зуучлагч банк, санхүүгийн байгууллагуугүйгээр өөрийн хөрөнгө, мөнгөө удирдах боломжийг олгож, их өгөгдөл, хиймэл оюун ухааны тусламжтайгаар огт танихгүй хэн нэгэнд ямар нэгэн эрсдэлгүйгээр хөрөнгө, мөнгөө ашиглуулж, өгөөжийг нь хүртэж, блокчэйн болон бүртгэлийн технологи дээр хөндлөнгийн ямар ч нөлөөгүйгээр гүйлгээний мэдээлэл хадгалагдаж, ухаалаг гэрээ үүсэн баталгааждаг эрин үед бид амьдарч байна.

Хэдийгээр технологийн хөгжил нь бидний урьд өмнө бүрэн төсөөлж байгаагүй олон тооны үр ашгийг зах зээл, хэрэглэгчдэд авчирч буй хэдий ч шинэ тутам хөгжиж буй технологийн дэвшилд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт зохицуулалтын хоцрогдол, кибер аюулгүй байдал болон өгөгдлийн сангийн хадгалалт, хамгаалалт, нэг нэгнээсээ өндөр хамаарал бүхий технологийн шийдлүүд зэрэг шинэ төрлийн эрсдэлүүд үүсэн ирээдүйд санхүүгийн зах зээлийн оролцогчдыг багагүй тооны сорилтууд хүлээж байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛЛОО



Сэндбоксын зөвлөлийн дөрөвдүгээр хуралдаан 12 дугаар сарын 26-ны өдөр болж “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл болон сэндбоксын орчинд туршигдаж буй хоёр, шинээр турших гурван бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу нийт зургаан асуудал хэлэлцлээ.

Хуралдааны үр дүнд цахим мөнгөнд суурилсан “Монпэй” дижитал бонд сэндбоксын орчинд амжилттай туршигдан гарсан бол Монимаркет вэб системээр дамжуулан репо хэлцлийн хүсэлт хүлээн авах, хэлцлийн дагуу худалдах, худалдан авах үйлчилгээг сэндбоксын зохицуулалтын орчинд ахин нэг жилийн хугацаанд туршихаар боллоо.

### СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД ШИНЭ ТӨРЛИЙН ДАРААХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ОРЛОО

Зээлмн платформоор дамжуулан олгох P2P зээлийн үйлчилгээ, Финберри платформд суурилсан зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ, Лайка платформоор дамжуулан даатгалын бүтээгдэхүүн санал болгох, худалдах цахим үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд нэг жилийн хугацаанд туршихаар боллоо.

Зээлмн платформоор дамжуулан олгох P2P зээлийн үйлчилгээ нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй үйлчилгээ бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглаж байгаагаараа онцлог давуу талтай. Харин Финберри платформд суурилсан зээл, урамшуулал, хандивын хамтын санхүүжилтийн үйлчилгээний хувьд жижиг дунд бизнес

эрхлэгчид, аж ахуй нэгжүүдэд төслийн санхүүжилтийн хэрэгцээгээ түргэн шуурхай шийдэх боломжийг санал болгож буй бөгөөд манай улсын санхүүгийн системд дээрх төрлийн хамтын санхүүжилтийн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын орчин хараахан бүрдээгүй байгаа юм. Мөн Лайка платформ нь хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлийн газрын зураглалд суурилсан үнэлгээний платформ хөгжүүлж даатгалын эрсдэлийг үнэлэх зэрэг олон төрлийн давуу талыг хэрэглэгчдэд санал болгож буй юм.

### “СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ЖУРАМ”-ЫН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЛЭЭ

Сэндбокс зохицуулалтын орчин нь технологийн дэвшилд суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал орчинд турших, амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, онцлогт тохирсон зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиглэлд зах зээлийн оролцогчид болон бодлого гаргагчид хамтран ажиллах боломжийг олгодог зохицуулалтын арга хэрэгсэл бөгөөд манай улсын санхүүгийн зах зээлд нэвтрээд нэг жилийн хугацаа өнгөрч байна.

Сэндбокс зохицуулалтын орчин нь зах зээлд нэвтрээд удаагүй хэдий ч алтернатив санхүүгийн зах зээл хурдтай хөгжиж технологид суурилсан шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэн санхүү, үйлчилгээний салбар цахим хөгжилд шилжиж байгаатай холбогдуулан салбарын шинэчлэлтэд нийцсэн өөрчлөлтийг тус зохицуулалтын орчинд хийх зайлшгүй шаардлага үүсэж байна.

Иймд зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн өмнө батлагдсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газар, нэгжүүдээс ирүүлсэн саналыг тусгаж, Сэндбоксын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлжээ.

Тус журмын шинэчилсэн найруулгаар сэндрбоксоод орох хүсэлтийг хугацаа харгалзахгүй хүлээн авах, сэндрбоксын орчинд шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдалгүй турших боломж бүрдэж, сэндрбоксын оролцогчдоод тавигдах шаардлага, үйл ажиллагаатай холбоотой харилцаа нь илүү тодорхой болж байна. Мөн одоо мөрдөгдөж буй журмын санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь тус тусдаа сэндрбоксын нэгжтэй байна гэсэн зохицуулалт нь журмын шинэчилсэн найруулгад Сэндрбоксын албыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлдэг байхаар тусгагдсан.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ГАРЛАА



Санхүүгийн зохицуулах хороо “Компанийн засаглалын кодекс” –ийг шинэчлэн баталж, “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл” –д бүртгэснээр

нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүргийг хүлээсэн. Энэ дагуу 116 зохицуулалттай этгээдийн кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахад өнгөрсөн оны наймдугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ 55.3 хувийн гүйцэтгэлтэй байсан. Санхүүгийн зохицуулах хорооноос мөн үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрт зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч өнгөрсөн сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай 3 салбарын кодексийн хэрэгжилт дунджаар 16.4 хувиар өссөн байна. Ингэснээр компанийн засаглалын чанар буюу кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд суурилсан компанийн засаглалын зэрэглэл тогтоох ажил дээр дурдсан салбаруудад хэрэгжиж эхэллээ.

Зохицуулалттай этгээдийн кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлэх, үнэлгээний нэгдсэн тайлан, судалгаа гаргах болон салбарын засаглалын зэрэглэл тогтоох нь компанийн засаглалын чиг хандлага, эрсдэлийг тодорхойлох, салбартаа засаглалаар тэргүүлэгч компаниудыг тодруулах ач холбогдолтой. Нөгөө талаар компанид өөрийн засаглалын түвшинг бусадтай харьцуулах, сайжруулахад нь зориулсан сайн жишгийг бий болгох, үйл ажиллагаандаа

эрсдэлийн дүн шинжилгээ хийх засаглалын үзүүлэлтийг бий болгосноор үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөөлөх зэрэг олон давуу талтай юм. Санхүүгийн зохицуулах хорооноос ч мөн салбар тус бүрийн зохицуулалттай этгээдийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ, нэгдсэн судалгааг тогтмол хийх ба үнэлгээний дүнг компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох, засаглалын зохицуулалтын орчныг боловсронгуй болгоход болон зөвшөөрөл олгоход дүн шинжилгээ хийх, олон нийтэд мэдээлэл өгөхөд ашиглах юм.

## “ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР” –ЫГ БАТАЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо “Хадгаламж, зээлийн хоршооны ажилтны ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар” –ыг баталлаа. Үлгэрчилсэн загварт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн болон гүйцэтгэх захирал, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоолоо. Түүнчлэн түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбоотой шаардлагыг мөн тодорхойлсон юм. Иймд нийт хадгаламж, зээлийн хоршоод энэхүү үлгэрчилсэн загварыг удирдлага болгон чиг үүрэг, үйл ажиллагааныхаа цар хүрээ, онцлогийг харгалзсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлэхийг зөвлөж байна.



Ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр хадгаламж зээлийн хоршоодын засаглал, дотоод ардчилал, гишүүдийн хараат бус оролцоог бэхжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах механизм сайжрах цаашлаад зах зээлийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлэх зэрэг олон давуу талтай.

## ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖАА ХИЙХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХААР ХОЛБОГДОХ ТАЛУУДАЙ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос нүүрсний арилжааг нээлттэй, ил тод, шударгаар зохион байгуулах, цахимаар арилжаалах бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд арилжаа зохион байгуулах этгээд болох “Монголын хөрөнгийн бирж”



ХК, нүүрс худалдагч талаас “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК-ийн төлөөллүүдтэй өнөөдөр уулзлаа. Энэ үеэр шаардлагатай арга хэмжээнүүдийг шуурхай авч хэрэгжүүлэх талаар чиглэл өгч, арилжааны заавар,



маягтуудын талаар хэлэлцсэн юм.

Засгийн газраас 2022 оны 466 дугаар тогтоолоор нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортод гаргах нүүрсийг цахимаар нээлттэй арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталсан. Уг журмын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.



## ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГЭЭС ТАЛАРХЛЫН ЦОМ ГАРДУУЛАВ

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) –ээс “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хэмээн Санхүүгийн зохицуулах хороонд талархлын цом гардууллаа.

Тус нийгэмлэгээс даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй даатгалын зохицуулалтыг сайжруулах зорилгоор дээрх хөтөлбөрийг долоон улсад хэрэгжүүлсний нэг нь Монгол Улс юм. Хөтөлбөрийн “Бүс нутгийн удирдах зөвлөл”-ийн гишүүнээр Санхүүгийн зохицуулах хороо ажиллахын зэрэгцээ хөтөлбөрт хамрагдсан улс орнуудын санал солилцох уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд дотоодын хүртээмжтэй даатгал болон түүнд тавигдах шаардлагыг тодорхойлж, даатгалын бүтээгдэхүүний судалгаа, зохицуулалтын орчны үнэлгээг хийсэн. Ингэснээр даатгалын компаниудын хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн борлуулах сонирхол дээшилж, даатгалын бүтээгдэхүүнүүдийн тоо ч нэмэгдсэн. Тодруулбал, даатгалд хамрагдах боломж хязгаарлагдмал хэрэглэгчдэд хүргэх борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг нэвтрүүлэхэд анхаарч ажилласан юм.

Филиппин Улсын Манила хотноо болсон хаалтын арга хэмжээний үеэр ийнхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хэмээн цом гардуулсан байна.

## НҮҮРСНИЙ ЦАХИМ АРИЛЖААНЫ ТУРШИЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА

УИХ-аас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль баталсантай холбогдуулан нүүрсний цахим арилжааг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан хийхийг Засгийн газарт, цахим арилжаанд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан. Түүнчлэн “Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталсан билээ. Энэ дагуу нүүрсний арилжааг нээлттэй, ил тод цахимаар арилжаалах бэлтгэл ажлыг хангах хүрээнд өнөөдөр “Энержи ресурс” ХХК-ийн худалдах баяжуулсан коксжих нүүрсний цахим арилжааны туршилтыг биржийн нүүрсний спот

гэрээний дуудлага арилжааны системээр дамжуулан амжилттай хийлээ.

Энэ удаагийн туршилтын дуудлага арилжаагаар 12,800 тонн нүүрс худалдах захиалгыг худалдагч талаас өгсөн бөгөөд арилжаанд оролцогч этгээдүүдээс ирүүлсэн захиалгаас хамаарч анхны санал болгосон үнэ 12.2 хувь өсөж, арилжаа амжилттай явагдлаа. Нүүрсний цахим арилжаатай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос арилжаа зохион байгуулах этгээд болон нүүрс худалдагч талуудтай хамтран ажиллаж, холбогдох чиглэл, саналыг өгч ажиллаж байна.



## МОНГОЛЫН БИРЖҮҮДИЙН НЭГДСЭН ХОЛБООТой ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо Монголын биржүүдийн нэгдсэн холбоотой хамтран ажиллахаар хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Уг арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Хяналт, шалгалт зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-ын гүйцэтгэх захирал С.Нямгэрэл, “Комплекс дижитал экосистем” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганбаатар, “Дижитал эксчейнж Монголиа” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэжаргал нар оролцлоо.



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун энэ үеэр “Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарт үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, хяналт тавих, холбогдох эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн орчин бүрдсэнтэй

холбогдуулж Санхүүгийн зохицуулах хороо нэр бүхий виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгээд байна. Үүнтэй холбоотойгоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон холбогдох 10 гаруй харилцааг зохицуулсан найман журмын төслийг боловсруулах ажилд холбооноос мэргэжлийн санал, зөвлөмжийг өгч ажилласанд юуны өмнө талархлаа илэрхийлж байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журмын хүрээнд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх шаардлагын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 11 компаниас 10-ийг гишүүнчлэлээр бүртгэсэн тул ээлжит хуралдаанаар хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар шийдвэрлэсэн.



Цаашид хамтдаа салбараа хөгжүүлэх, зохицуулалтын зохистой орчин бүрдүүлэх, мэргэжлийн оролцогчдоо чадавхжуулах, мэргэшүүлэх, эрх ашгийг нь хамгаалах гээд олон ажил биднийг хүлээж буй. Нөгөө талаар Та бүхний хувьд ч санхүүгийн салбарын бусад холбоодтой хамтдаа хөгжиж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, холбогдох хууль эрхзүйн зохицуулалт, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн төслүүдэд санал өгөх, хамтран боловсруулах, сургалтын нэгдсэн стандарт, ижил үнэлгээтэй болох боломж бүрдэнэ. Ингээд бидний хамтын ажиллагаа үр өгөөжтэй байх болтугай” гэсэн юм.

Хоёр тал ийнхүү гэрээг үзэглэснээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагчтай холбогдуулан тодорхой төрлийн дүгнэлтийг холбооноос гаргуулах, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах цаашилбал Монгол Улсын виртуал хөрөнгийн салбарт үйлчилгээ үзүүлэгчдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хөгжлийн бодлого, стратегийг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлд хамтран ажиллах юм.

## БАЙР СУУРЬ

### ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

*Энэ удаагийн ярилцлагаар сэндрокс зохицуулалтын орчны өнөөгийн байдлын талаар Сэндроксын зөвлөлийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуунтай ярилцлаа.*



*Эхлэл нь 1-р нүүрт*

төлөөллүүд холбогдох шийдвэр, зөвлөмжийг гарган ажилладаг.

Мөн тус Зөвлөлийн дэргэд сэндроксын орчинд орох хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын бодлого, хяналтын газруудтай хамтран сэндроксын туршилтын хугацаанд оролцогчдын үйл ажиллагааг хянан, шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий Сэндроксын алба Санхүүгийн зохицуулах хорооны бүтцэд шинээр байгуулагдан ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл, Сэндроксод орох хүсэлтийн материалыг Сэндроксын алба хүлээн авч, холбогдох бодлого, хяналтын мэргэжилтнүүдийн саналыг тусган судалгаа, дүгнэлтийг боловсруулж, Сэндроксын зөвлөлд танилцуулан, Зөвлөл нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндроксод туршигтай холбоотой дүгнэлт, зөвлөмжийг гарган санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлэх гэсэн ерөнхий процессоор тус зохицуулалт маань хэрэгжиж байна.

**Өнөөгийн байдлаар сэндрокс зохицуулалтад хэдэн байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж байна вэ? Сэндроксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж хэрэгцээ, шаардлага, зах зээлийн эрэлт хэр зэрэг байна гэж та харж байна вэ?**

Сэндрокс зохицуулалтын орчин анх Их британи улсад бий болж, саяхныг хүртэл зөвхөн Сингапур, Австрали зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд л санхүүгийн зохицуулалтад нэвтрүүлсэн харьцангуй шинэ ойлголт байсан. Бидний хувьд ч уг зохицуулалтыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхдээ хөгжиж буй харьцангуй жижиг зах зээлтэй манай улсын хувьд зах зээл хэрхэн хүлээж авах талаар эргэлзээтэй байсан. Харин Сэндрокс зохицуулалт нэвтэрснээс хойш жил гаруйн

**Та “Сэндрокс зохицуулалтын орчны журам”, түүний хэрэгжилт, сэндроксын үйл ажиллагаа, шийдвэр гаргах процессын тухай уншигчдад товч мэдээлэл өгөөч.**

“Сэндрокс зохицуулалтын орчны журам” нь 2021 оны 3 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтарсан тушаалаар батлагдсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөд сэндрокс зохицуулалтын орчин бий болгох, бүрдүүлэхтэй холбоотой заалт туссан.

Журамд сэндроксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээг туршиж, туршилтын хугацааг сунгах, мөн хугацаа нь дуусах үед сэндроксын орчноос гаргах зэрэг шийдвэрийг гарган, холбогдох зөвлөмжөөр хангах чиг үүрэг бүхий Сэндроксын зөвлөл байна гэж заасан байдаг. Тус заалтын дагуу 2021 оны 10 дугаар сард Сэндроксын зөвлөл байгуулагдсан. Тус зөвлөлд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам зэрэг төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнаас гадна судлаач, эрдэмтдийн төлөөлөл болох Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн захирал, Санхүү эдийн засгийн дээд сургуулийн ректор зэрэг санхүү болон технологийн салбарын

хугацаанд сэндроксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших 15 хүсэлт ирсэн нь зах зээлд эрэлт, хэрэгцээ байгааг мөн манай улсын санхүүгийн зах зээлийн оролцогчид техник, технологийн хурдтай хөгжлөөс хоцролгүй алхаж буйг харуулж байна.

Энэ хугацаанд тус орчинд 2 компани бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын Зөвлөлийн хуралдааны шийдвэрээр 1 компани нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сэндроксын орчинд амжилттай туршин сэндрокс зохицуулалтаас гарч, нөгөө компани нь өөрсдийн шинээр нэвтрүүлж буй мөнгөний зах зээлийн платформын үйлчилгээг үргэлжлүүлэн хөгжүүлж дахин 1 жилийн хугацаатайгаар туршихаар болсон. Мөн тус хуралдаанаар сэндроксын орчинд шинээр 3 компани бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршихаар болсон. Өөрөөр хэлбэл одоогийн байдлаар нийт 4 компани өөрсдийн хөгжүүлсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сэндроксын орчинд туршиж байна.

Түүнчлэн санхүүгийн зах зээлийн оролцогчдын зүгээс сэндроксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршихаас гадна өөрсдийн хөгжүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтын талаар зөвлөгөө, мэдээлэл авах, одоо хэрэгжиж буй зохицуулалтын орчны талаар санал, бодлоо илэрхийлэх зэргээр Сэндроксын албатай байнга холбогдон ажиллаж байна. Сэндрокс зохицуулалт нь нэг ёсондоо санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон технологийн шийдлийг нэвтрүүлж буй санхүү, технологийн компаниудыг холбох нэг төрлийн гүүр нь болж буй юм.

**Сэндроксод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн онцлог нь юу вэ? Энд туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь манай улсын санхүүгийн зах зээлд цоо шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ гэж ойлгож болох уу?**

Сэндроксын орчинд мөнгөний зах зээл дээр үйл ажиллагаа явуулах зуучлалын платформын үйлчилгээ, P2P зээлийн үйлчилгээ, хамтын санхүүжилтийн үйлчилгээ болон технологид суурилсан даатгал буюу инсуртекийн үйлчилгээ зэрэг 4 бүтээгдэхүүн, үйлчилгээ туршигдаж байна.

Манай улсын санхүүгийн зах зээлийн хувьд Монголбанк, арилжааны банкуудын хооронд л мөнгөний зах зээлийн хэлцэл хийгддэг бөгөөд санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдын хувьд мөнгөний зах зээлийн идэвхтэй арилжаа хийгддэггүй. Гэтэл хөрөнгийн болон мөнгөний зах зээл

хослон ажилласнаар санхүүгийн зах зээл дэх нөөц хөрөнгө тасралтгүй, үр ашигтайгаар ашиглагдах боломж бүрдэж байна. Учир нь хөрөнгийн зах зээл дээр ихэвчлэн урт хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэл арилжаалагддаг бол мөнгөний зах зээл дээр богино хугацаат санхүүгийн хэрэгсэл арилжаалагддаг шинж чанартай байдаг. Иймд мөнгөний зах зээл дээр үйл ажиллагаа явуулах зуучлалын платформын үйлчилгээ амжилттай туршигдан, зах зээлд нэвтэрч чадвал санхүүгийн зах зээлийн хөрвөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлнэ.

P2P зээлийн үйлчилгээний хувьд манай улсын санхүүгийн зах зээлд шинээр нэвтрэхээр сэндроксын орчинд туршигдаж буй үйлчилгээ бөгөөд зээлийн үнэлгээндээ хиймэл оюун ухаан ашиглаж, зээлийн бүртгэлээ блокчэйн технологи дээр хийж буйгаараа онцлогтой. Харин хамтын санхүүжилтийн үйлчилгээний хувьд дэлхийн улс орнуудад түгээмэл нэвтэрч буй санхүүгийн үйлчилгээ хэдий ч манай улсын хувьд холбогдох эрх зүйн зохицуулалт нь хараахан бүрдээгүй байгаа. Нийт 4 төрлийн хамтын санхүүжилтийн үйлчилгээ байдгаас хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилттэй холбоотой зохицуулалтын орчныг бүрдүүлэхээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан байгаа бол үлдсэн 3 төрөл болох зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээний зохицуулалт хараахан бүрдээгүй байгаа бөгөөд сэндроксод шинээр орсон нэг компани нь тус 3 төрлийн хамтын санхүүжилтийн үйлчилгээг турших юм.

Манай улсын эдийн засаг, санхүүгийн зах зээл дэх томоохон асуудлуудын нэг нь зээлийн өндөр хүү юм. Хэдийгээр эдийн засгийн нөхцөл байдал, санхүүжилтийн өндөр өртгөөс шалтгаалан зээлийн хүү өндөр тогтож байгаа боловч зах зээлд олон төрлийн шинэ бүтээгдэхүүн, нэвтрүүлэх замаар санхүүжилтийн өндөр эрэлтийг хангах, мөн технологийн дэвшлийг ашиглан зээлийн үйлчилгээний өртгийг багасгах замаар зээлийн хүүг тодорхой хувиар бууруулах боломжтой. Иймд дээр дурдсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд зах зээлд амжилттай нэвтэрч чадсан тохиолдолд энэ асуудлыг шийдэхэд ач холбогдолтой юм.

Мөн технологийн дэвшлийн нөлөөгөөр хэрэглэгч даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг ямар нэгэн зуучлагчгүйгээр, өөрсдийн эрсдэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ялгаатай хураамж, нөхцөлтэйгөөр хүлээн авах боломжтой. Уг боломжийг олгосон технологийн шийдэл бүхий даатгалын үйлчилгээний цахим платформ сэндроксын

орчинд туршигдаж байгаа юм. Мэдээж даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, хэрэглэгчид амар хялбар байдлаар даатгалын үйлчилгээг авч, эрсдэлээ даатгуулж хэвших зэрэг олон зэрэг үр нөлөөг даатгалын салбарт нэвтэрч буй технологийн дэвшлээс хүлээж байна.

### **Цаашид сэндбокс зохицуулалтын орчны хүрээнд ямар ажлууд хийхээр төлөвлөж буй талаарх асуултаар энэ удаагийн ярилцлагаа өндөрлөө.**

Технологид суурилсан санхүүгийн зах зээл хурдтай хөгжихийн хэрээр тус салбарын хяналт, зохицуулалтын орчинд ч мөн өөрчлөлт, шинэчлэлт тасралтгүй хийгдэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Хэдийгээр сэндбокс зохицуулалт зах зээлд нэвтрээд удаагүй ч зах зээлд нэлээдгүй өөрчлөлт өрнөсөн. Ковид-19 цар тахлаас шалтгаалсан хөл хорио ч мөн санхүү, үйлчилгээний салбарын цахим шилжилт хурдтай явагдахад нөлөөлсөн байх. Иймд зах зээлийн уг өөрчлөлтөд нийцүүлэн өмнө батлагдсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэх, холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлага үүссэн бөгөөд журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.

Одоо мөрдөгдөж байгаа журмаар сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтийг жилд 3 болон 9 дүгээр саруудад ердөө 2 удаа хүлээн авах боломжтой. Энэ зохицуулалт нь технологи хөгжүүлж буй компаниудад хугацаа алдах, нэгэн ижил хурдаар ажиллахыг оролцогч байгууллагуудаас шаардах зэрэг нэлээн уян хатан бус нөхцөлийг үүсгээд байгаа бол журмын шинэчилсэн найруулгаар сэндбоксоод оролцох хүсэлтийг хугацаа харгалзахгүй хүлээн авах боломж бүрдэнэ. Мөн санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь тус тусдаа сэндбоксын асуудал хариуцсан нэгжтэй байна гэсэн зохицуулалт нь журмын шинэчлэлээр Сэндбоксын албыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлдэг байхаар өөрчлөлт орох бөгөөд санхүүгийн зах зээлийн оролцогчид маань зөвхөн нэг албатай шууд харилцан, тухайн албаар дамжуулан зохицуулагч байгууллагуудтай харилцаж, өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших боломж бүрдэх юм.

Түүнчлэн сэндбокс зохицуулалт нь анх нэвтэрсэн цагаасаа хойш зарим өндөр хөгжилтэй орнуудад хэд, хэдэн төрөл болон хөгжиж байна. Тухайлбал сэндбокс зохицуулалтаар анхдагч Англи, Сингапур улсууд л гэхэд зохицуулалтын сэндбоксоос гадна, инкубаторын үүрэг гүйцэтгэх илүү гарааны үе шатандаа яваа компаниудад зориулсан сэндбокс, шинээр нэвтэрсэн зохицуулалтад бүтээгдэхүүн, үйлчилгээг оруулахдаа дамжуулах зорилго бүхий хурдасгасан сэндбокс зэрэг хэд хэдэн төрлөөр нь сэндбокс зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Иймд бидний зүгээс сэндбокс зохицуулалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулахаас гадна, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх талаар холбогдох судалгаа, бодлогыг боловсруулах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Мөн сэндбокс зохицуулалт нь технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах цор ганц арга хэрэгсэл биш, зөвхөн нэг хэлбэр нь бөгөөд цаашид бидэнд санхүүгийн зах зээлийн зохицуулалтад бусад төрлийн инновацын хурдасгуур хэрэгслүүдийг ашиглах, санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагаанд регтек, суптекийг нэвтрүүлэх зэрэг олон ажлууд хүлээгдэж байна.

Санхүүгийн зах зээлд явагдаж буй технологийн хурдтай хөгжил болон сэндбокс зохицуулалтыг хэрэгжүүлж буй арга, туршлагаасаа олон улсад танилцуулах, өөрийн орны санхүүгийн зах зээлийн хөгжлийг сурталчлан таниулж, бид технологийн хөгжлөөс хоцроогүй яваагаа олон улсад харуулах нь цаашид санхүүгийн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвартай зах зээлийг хөгжүүлэн эдийн засгаа дэмжихэд чухал нөлөөтэй тул энэ төрлийн ажлуудыг хэрэгжүүлэх нь ч мөн зайлшгүй чухал байна.

### **Ярилцсанд баярлалаа.**

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НОГООН ФИНТЕК

1960 оноос эхлэн “Хүн ба байгаль” хоорондоо зохицож амьдрах шаардлагыг хүн төрөлхтөн ухамсарласнаас хойш байгаль орчин, эдийн засагт гарах сөрөг нөлөөллүүд нь экологийн тэнцвэрт байдлыг хангаж амьдрахад хүргэсэн. Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гурвалсан тэнцвэрийг хангахад дэлхий даяар 2–3 их наяд ам.доллар хэрэгтэй тухай судалгаа байдаг.

Гэвч ногоон, тогтвортой санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх эрхзүйн орчин, стандарт, зарчмууд боловсруулагдсан хэдий ч ногоон төслүүдэд дээрх санхүүжилтийн хэмжээ бага хэвээр байна. Тухайлбал ногоон бондоор дамжуулан татан авсан санхүүжилт нийт бондын санхүүжилтийн 3.0–4.0 хувийг эзэлж байна. Тогтвортой санхүүжилтээр дамжуулж ногоон төслүүдэд хөрөнгө оруулалт татахад ил тод буюу тайлагналын асуудал үүсдэг. Учир нь ногоон санхүүжилтэд зориулж татсан хөрөнгө оруулалтыг зорилтот бүлэгт ашиглаж буй эсэх, түүний үр дүн ямар байгаа тухайд хөрөнгө оруулагчид анхаарал хандуулдаг. Нөгөө талаасаа ногоон санхүүжилтийн талаарх мэдээллийг ил тод тайлагнах нь санхүүжилт авагч талд өртөг өндөртэй байдаг нь тулгамдсан асуудал болдог.

Дээрх тулгамдсан асуудлыг финтек буюу технологийн шийдэл болон их өгөгдлөөр шийдэхээр нэлээдгүй олон төслүүд болон инновацын төвүүд ажиллаж байна. Үүний

нэгэн жишээ нь Сингапурын төв банкны хэрэгжүүлж буй “Ногоон финтек” төсөл юм.


Технологи болон тогтвортой байдал нь санхүүгийн үйлчилгээний ирээдүйг тодорхойлох хүчин зүйлүүдийн нэг ба Сингапур улсад финтекийн аялал 2015 онд эхэлсэн бол 2019 онд ногоон санхүүжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ногоон санхүүжилтэд тулгараад буй асуудлыг финтекээр шийдвэрлэх стратегийг тодорхойлсон.

“Хүртээмжтэй нийгэм, тогтвортой дэлхийн төлөө санхүү болон технологийн хүчийг хамтад нь цогцлоох ногоон финтек зорилго” гэж Сингапурын төв банкны Ажлын албаны дарга онцолсон байдаг.

Ногоон финтек төсөл нь ил тод, итгэлтэй, үр дүнтэй байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын экосистемийг бүрдүүлэхэд технологи болон өгөгдлийг холбох юм.

Сингапурын Төв банкны хөгжүүлсэн ногоон финтекийн платформ ногоон финтекийн технологийн шийдлийг хөгжүүлэгч болон ногоон төсөл гаргагчдыг хөрөнгө оруулагч, санхүүгийн байгууллагуудтай уулзах зах зээл нь болохоос гадна их өгөгдөлд суурилсан мэдээллийн ил тод байдлыг хангах бүтэцтэй.

### Ногоон финтек төслийн платформ



Эх сурвалж: Green FinTech (mas.gov.sg)

## ФИНТЕК БА РЕГТЕК

### СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ХӨГЖИЛ, ДЭВШИЛ

Сэндбокс орчин нь анх 2016 онд Их Британи улсад үүсэж хөгжсөн бөгөөд тухайн улсын туршлагад үндэслэн олон улс орнууд сэндбокс зохицуулалтын орчныг шинээр нэвтрүүлсээр байна. Дэлхийн банкны 2020 оны судалгаанаас харахад сэндбокс зохицуулалтыг санхүүгийн зохицуулалтын хэлбэрээс хамааран төв банк, эсхүл санхүүгийн зохицуулагч байгууллага нь хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд бодлогод суурилсан, инновацад суурилсан, сэдэвчилсэн, хил дамнасан зэрэг түгээмэл 4 төрлийн сэндбокс зохицуулалтын орчинд улс орнууд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж байна (Хүснэгт). Зарим улс орнууд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ салбарын онцлогоос хамааруулан 2-оос 3 өөр сэндбоксын орчныг нэвтрүүлжээ. Тухайлбал, сэндбоксын эрх зүйн орчныг анх бүрдүүлсэн Их Британи улс нь 2020 онд нэмж дижитал сэндбоксыг бий болгосон бөгөөд олон нийтэд нээлттэй мэдээллийн багцад нэвтрэх, түүнийг ашиглах боломжийг олгох чиглэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлтийн дэмжин ажиллаж байна.

Харин Хонг-Конг улс нь даатгал, үнэт цаас болон төлбөр тооцоо санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ туршдаг 3 төрлийн сэндбокс зохицуулалтын орчинтой бол Сингапур улс нь 2016 онд сэндбокс, 2019 онд сэндбокс экспресс, 2022 онд

сэндбокс пласыг нэвтрүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Үүний сэндбокс нь шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл болон үр ашгийг илүү нарийвчлан судлах шаардлагатай харьцангуй нарийн төвөгтэй бизнес загвар бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг турших сэндбокс орчин бол сэндбокс экспресс нь харьцангуй бага эрсдэлтэй, зах зээлд танигдсан, сэндбоксод туршигдах хүрээ, мөрдөх хязгаарлалт, тавигдах шаардлагууд нь урьдчилсан тодорхойлох боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээг туршдаг орчин юм. Энэ сэндбоксын туршилтын хугацаа нь өмнөх сэндбокстой харьцуулахад харьцангуй богино байдаг. Харин сэндбокс плас нь санхүүгийн шинэ технологи, финтек компаниудад бодлого зохицуулалт болон санхүүгийн туслалцаа үзүүлэх зорилготой нэг цэгийн үйлчилгээ юм. Энэ нь уламжлалт сэндбокстой харьцуулахад хөгжлийн хувьд илүү эрт үедээ яваа компаниуд оролцох боломжтой бөгөөд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн дэмжлэгийг үзүүлдгээрээ онцлогтой.

Хүснэгт. Олон улсын сэндбоксын төрлүүд

Бодлогод суурилсан сэндбокс	Инновацад суурилсан сэндбокс	Сэдэвчилсэн сэндбокс	Хил дамнасан сэндбокс
<p>Тодорхой зохицуулалт эсхүл бодлогын нөлөөг үнэлэх зорилгоор бүтээгдэхүүн, үйлчилгээг туршдаг сэндбокс орчин.</p>	<p>Зохицуулалттай зах зээлд гарах зардлыг бууруулж, шинэ бизнесийн загваруудын зах зээлд амьдрах чадварыг шалгах боломжийг олгож, инновацийг дэмждэг сэндбокс орчин.</p>	<p>Тодорхой бодлого, инновацийн хөгжлийг хурдасгах, эсхүл тодорхой нэгэн дэд салбар, хүн амын тодорхой бүлэгт чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмждэг сэндбокс орчин.</p>	<p>Санхүүгийн байгууллагуудын хил дамнасан үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих зорилготой сэндбокс орчин.</p>

Түүнчлэн, сэдэвчилсэн сэндрокс зохицуулалтын орчинтой улсуудын нэг нь Энэтхэг улс юм. Энэтхэгийн төв банк нь 2019 онд "Бага дүнтэй төлбөрийн гүйлгээ", 2020 онд "Хил дамнасан төлбөрийн гүйлгээ", 2021 онд "Бичил, жижиг, дунд үйлдвэрийн зээл" сэдвийн хүрээнд сэндроксод орох хүсэлт ирүүлэхийг уриалсан бол 2022 онд "Санхүүгийн луйвраас урьдчилан сэргийлэх, бууруулах" сэдвийг зарлан дараах 6 хүсэлт гаргагчийг сэндрокс зохицуулалтын орчинд оруулсан бөгөөд сэндроксын туршилт 2023 оны 2 дугаар сараас эхэлнэ хэмээн мэдээлсэн:

- ◆ **Bahwan CyberTek компани:** Bahwan Cybertek компанийн 'rt360 бодит цагийн хяналтын систем' нь зээлийн дансны гүйлгээ, процессыг тасралтгүй, бодит цаг хугацаанд хянах цогц хяналтын механизм юм.
- ◆ **Credirwatch компани:** Энэхүү компанийн сэндрокс орчинд санал болгож буй 'Credirwatch EWS' мэдээллийн аналитик шийдэл нь зээлдэгчдэд үүссэн хүндрэлийн анхны шинж тэмдгийг илрүүлэхийн тулд төрийн болон хувийн мэдээллийн эх сурвалжийн мэдээллийг харж зээлийн хяналт, залилан мэхлэлтийг тодорхойлох эрт дохиоллын систем юм.
- ◆ **enStage Software (Wibmo) компани:** Энэхүү компанийн сэндрокс орчинд санал болгож буй 'Trident FRM' бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн OTP-гүйгээр бага дүнтэй гүйлгээ хийх эрсдэлд суурилсан баталгаажуулалтын шийдэл юм.
- ◆ **HSBC компани:** Энэхүү компанийн сэндрокс орчинд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хиймэл оюун ухаан болон машин сургалтад суурилсан дэвшилтэт технологиор дамжуулан гүйлгээ, контекстийн мэдээллийг ашиглан банк, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаанд үндэслэн картын бус луйврыг илрүүлдэг.
- ◆ **napID Cybersec компани:** Энэхүү компанийн сэндрокс орчинд санал болгож буй "napID Fraud Filter Layer" бүтээгдэхүүн, үйлчилгээ нь нэвтрэх маягт, төлбөрийн маягт, АТМ, ПОС машинуудыг түгжих, үүнийг зөвхөн эрх бүхий хэрэглэгч napID Zero-Factor Authenticator программаар дамжуулан гүйлгээг эхлүүлэх боломжийг олгоно.
- ◆ **Trusting Social компани:** Энэхүү компанийн сэндрокс орчинд санал болгож буй "Trusting Social CI & AV" бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчийн оршин суугаа болон оффисын хаягийг урьдчилан таамаглахын тулд

хэрэглэгчийн утас ашиглалт, байршлын дохио болон бусад параметрууд дээр хиймэл оюун ухааны алгоритмуудыг ажиллуулж хаяг, байршлыг тогтоодог.

Цаашлаад, 2022 оны 12 сард Economic Times сэтгүүлийн мэдээлснээр Телангана мужийн засгийн газар нь Вэб 3.0-д суурилсан сэндрокс зохицуулалтыг орчныг нэвтрүүлэхэд бэлэн болж, сэндрокс зохицуулалтын орчин олон улсад нэгээр нэмэгдэж байна. Вэб 3.0 сэндрокс зохицуулалтын орчин нь оролцогч талуудад бүтээгдэхүүнээ турших, зохицуулагчдын зүгээс хүсэлтийг баталгаажуулах платформоор хангах зорилготой бөгөөд төвлөрсөн бус өгөгдөл, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан, найдвартай хадгалалт, хамгаалалт бүхий блокчэйн суурилсан орчин юм. Энэхүү Вэб 3.0 сэндроксоор дамжуулан старт-ап компаниуд өөрсдийн шийдлээ аюулгүй орчинд танилцуулж, зөв зохицуулалтын дэмжлэг, удирдамжийг хүлээн авах боломжтой бөгөөд энэ нь дэлхий нийтийн болон Энэтхэг улсын Вэб 3.0 салбарт томоохон түлхэц болно хэмээн бодлого боловсруулагчид үзэж байна.

Мөн Вэб 3.0 сэндрокс орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг туршсанаар тодорхойгүй, инновацад саад болж буй нөхцөл байдлыг тодорхойлох боломжтой болж зохицуулагч байгууллагын зүгээс бодит байдалд нийцсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэх боломж нээгдэж буй. Харин оролцогчдын зүгээс Веб 3.0 сэндроксоор дамжуулан старт-ап шаардлагатай өөрчлөлтүүдийг эрт үе шатанд хууль тогтоомжид нийцүүлэн хийх ба тодорхой бус байдлаас үүдэлтэй алдагдалд орохоос сэргийлэх боломжтой гэдгийг онцолжээ. Ийнхүү дээр дурдсанчлан, улс орнууд өөрийн зах зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогт тохируулан сэндрокс зохицуулалтын орчныг шинээр бий болгон өргөжүүлж байна.

## Судлаачийн индэр

### СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРМЫН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

/ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны мэргэжилтэн Б.Даваамаа  
davaamaa@frc.mn

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны мэргэжилтэн О.Лхагважаргал  
lkhagvajargal@frc.mn

#### ХУРААНГУЙ

Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодит орчинд турших, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон хууль, эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлэх зорилгоор улс орнууд сэндбокс зохицуулалтыг 2016 оноос эхлэн санхүүгийн зах зээлдээ нэвтрүүлж эхлээд байна. Өнөөгийн байдлаар сэндбокс зохицуулалтыг дэлхийн 60 гаруй улс нэвтрүүлээд байна. Харин Монгол улсын хувьд 2021 онд “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг баталж, технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Зохицуулагч байгууллагын хяналт дор хязгаарлагдмал орчинд, тодорхой цаг хугацаанд турших сэндбоксын орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Энэхүү судалгааны ажлаар технологийн дэвшилд суурилсан шинэлэг санхүүгийн үйлчилгээг зах зээлд нэвтрэхийг дэмжих олон улсын сэндбоксын сайн туршлага, стандартыг нэвтрүүлэх, сэндбокс зохицуулалтын орчныг сайжруулах зорилгоор нийт 13 орны сэндбоксын туршлага болон сэндбоксын журам, удирдамжийг судалж Монгол улсын сэндбоксын журамд тусгагдаагүй олон улсын сэндбоксын журмын заалтуудыг тодорхойлон сэндбокс орчны журмыг сайжруулахад холбогдох санал, дүгнэлтийг боловсрууллаа.

#### УДИРТГАЛ

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал буюу технологийн өндөр хөгжлийн нөлөөгөөр уламжлалт санхүүгийн зах зээлээс дэвшилтэт технологид суурилсан илүү ухаалаг санхүүгийн эко систем рүү улс орнууд хурдацтай шилжиж

байна. Үүнтэй холбоотойгоор санхүүгийн салбарт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, цаг хугацаа зардлыг хэмнэсэн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо эрс нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч урьд өмнө ашиглагдаж байгаагүй шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг даган санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал үүсэн, кибер халдлага гарч хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал алдагдах, мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэг үйлдэгдэх зэрэг олон тооны эрсдэлүүд үүсэж байна. Финтек бүтээгдэхүүнтэй холбоотой эдгээр нөхцөл байдлыг санхүүгийн уламжлалт аргаар зохицуулснаар компаниудад эрх зүйн орчны хатуу хязгаарлалтаас үүдэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ шийдлийг зах зээлд бий болгохоос зайлсхийх эсхүл санхүүгийн хяналт, зохицуулалтаас гадуур үйл ажиллагаа эрхлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Харин зохицуулагч байгууллагын зүгээс шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд зориулан хууль тогтоомжийг байнга өөрчлөх боломжгүй бөгөөд шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварт тохирсон хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ихээхэн хугацаа шаарддаг тул технологид суурилсан санхүүгийн үйлчилгээнд зохицуулалтын шинэ хэлбэрийн хэрэгцээ шаардлага бий болсон. Иймд улс орнууд финтек бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор инновацын хаб болон сэндбокс зохицуулалтын орчин гэсэн зохицуулалтын хэлбэрүүдийг ашиглаж байна.

Сэндбокс зохицуулалтын орчныг 2016 онд анх Их британи улс шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахад зарцуулах цаг

хугацаа, зардлыг бууруулах, зах зээлд нэвтэрч буй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх зорилгоор технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэхээс өмнө турших сэндрокс зохицуулалтын орчныг бий болгож олон улсад таниулсан. Үүнийг хөгжингүй болон хөгжиж буй орнуудын зохицуулагч байгууллагууд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, түүнчлэн инновацыг бий болгохыг дэмжихэд тохиромжтой бодлогын арга хэрэгсэл хэмээн үзэж, дэлхийн 60 гаруй улс сэндроксыг нэвтрүүлж, түүний эрх зүйн орчныг бий болгож, туршилтыг эхлүүлээд байна. Харин Монгол улсын хувьд санхүүгийн зах зээлд технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэхийг дэмжих зорилгоор “Сэндрокс зохицуулалтын орчны журам”-ыг баталж, технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Зохицуулагч байгууллагын хяналт дор хязгаарлагдмал орчинд, тодорхой цаг хугацаанд турших сэндроксын орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Тус журам нь 2021 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд журмын дагуу сэндроксын орчинд бүтээгдэхүүн турших хүсэлтийг жил бүрийн 3 болон 9 дүгээр сарын ажлын эхний 10 хоногт хүлээн авдаг. 2021–2022 онд нийт 15 байгууллага сэндроксын орчинд орох хүсэлт ирүүлснээс шаардлага хангасан 4 бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндроксын орчинд амжилттай туршиж байна. Сэндроксын орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ турших нь шинийг санаачлагчид болон зохицуулагч байгууллагын аль алинд нь уг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэхээс өмнө эрсдэлийг таньж урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах гэх мэт зохицуулалтын туршлага олж авах боломжийг олгодог.


Иймд энэхүү судалгааны ажлаар технологийн дэвшилд суурилсан шинэлэг санхүүгийн үйлчилгээг зах зээлд нэвтрэхийг дэмжих олон улсын сэндроксын сайн туршлага, стандартыг нэвтрүүлэх, сэндрокс зохицуулалтын орчныг сайжруулах зорилгоор нийт 13 орны сэндроксын туршлага болон сэндроксын журам/ удирдамжийг судалсан. Уг судалгаанд Австрали, Хонконг, Ямайка, Малайз, Саудын Араб, Сингапур, Шри-Ланка, Тайван, Тайланд, Их британи, Кени болон Нигер зэрэг улсуудын сэндроксын удирдамж/ журмыг судалж, “Сэндрокс зохицуулалтын орчны журам”-тай харьцуулан заалт бүрээр нь тулгаж, Монгол улсын сэндроксын журамд тусгагдаагүй олон улсын сэндроксын журмын заалтуудыг тодорхойлон сэндрокс орчны журмыг сайжруулахад холбогдох санал, дүгнэлтийг боловсрууллаа.

Энэхүү судалгааны ажил нийт 4 бүлэгтэй. Дараагийн бүлэгт сэндрокс зохицуулалтын орчны олон улсын өнөөгийн байдлын талаар танилцуулна. Судалгааны гурав, дөрөв дүгээр бүлэгт харгалзан олон улсын сэндрокс орчны зохицуулалт болон дүгнэлтийг оруулав.

## ОЛОН УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сэндрокс орчин нь анх 2016 онд Их Британи улсад үүсэж хөгжсөн бөгөөд энэхүү улсын туршлагад үндэслэн олон улс орнууд сэндрокс зохицуулалтын орчныг шинээр нэвтрүүлсээр байна. 2020 оны Дэлхийн банкны судалгаагаар 2016–аас 2020 оны хооронд нийт 57 улс 73 төрлийн сэндрокс орчинд технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг туршиж байна. Хязгаарлагдмал бодит орчинд бүтээгдэхүүн үйлчилгээгээ туршиж буй 57 орны 16 улс нь хөгжингүй улс, 41 улс нь хөгжиж буй улс орнууд байна.

Зураг. Олон улсын сэндрокс орчинд нэвтрүүлж буй сэндрокс, төрлөөр



Эх сурвалж: Дэлхийн банк

Түүнчлэн, олон улсад нэвтрүүлж буй сэндрбоксын орчныг төрлөөр нь ангилан харвал 63 хувь нь технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу финтекийн үйлчилгээг дэмжих, 10 хувь нь блокчэйн технологийн хөгжлийг дэмжих, 8 хувь нь технологид суурилсан даатгалын үйлчилгээ буюу инсуртек, 8 хувь нь төлбөр тооцооны үйлчилгээ, 5 хувь нь хэрэглэгчийг таних технологи, 3 хувь нь регтек буюу технологид суурилсан санхүүгийн хяналт зохицуулалтыг хөгжүүлэхэд чиглэсэн бол үлдсэн 3 хувь нь бусад төрөлд хамаарч байна.

Харин сэндрбокс орчноос амжилттай туршигдаж гарсан бүтээгдэхүүн үйлчилгээний 50 гаруй хувийг шууд зах зээлд нэвтрүүлэхэд уламжлалт зохицуулалт тохиромжгүй байсан тул хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийсний дараа зах зээлд нэвтрүүлэхээр болсон бол 38 хувийг нь бүртгэж, тусгай зөвшөөрөл олгон зах зээлд нэвтрүүлсэн. Энэ нь технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээнд уламжлалт санхүүгийн хууль эрх зүйн орчин тохиромжгүй байгааг харуулж байна. Харин үлдсэн буюу бүтээгдэхүүн үйлчилгээний 8 хувийн бизнесийн загварыг өөрчилж дахин сэндрбокс орчинд туршсан байна.

*Зураг. Олон улсын сэндрбокс орчны амжилттай туршилтын үр дүн*



Сэндрбокс орчин нь технологийн дэвшилд суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хязгаарлагдмал бодит орчинд туршиж, тухайн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирсон хууль эрх зүйн орчныг бий болгох боломж олгодог учраас сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орнууд сэндрбокс зохицуулалтын орчныг идэвхтэй нэвтрүүлж байна. Тухайлбал 2021–2022 оны хооронд Хавайн арлын орнууд болон Гана, Уганда, Оман, Соломон, Зимбабве гэх мэт хэд хэдэн улсууд сэндрбокс зохицуулалтын орчныг шинээр нэвтрүүлжээ. Цаашлаад Сэндрбокс зохицуулалтын орчны туршлагаараа тэргүүлэгч Их британи, Малайз болон Солонгос улсын сэндрбокс зохицуулалтын орчны талаар товч авч үзье.

## ИХ БРИТАНИ УЛС


Их Британи Улс нь 2016 онд сэндрбокс зохицуулалтын орчныг нэвтрүүлсэн анхдагч улс бөгөөд санхүүгийн үйлчилгээнд инновацыг нэвтрүүлж буй технологийн компаниуд, тусгай зөвшөөрөлтэй санхүүгийн байгууллагууд эсхүл, тохирох тусгай зөвшөөрөл, зохицуулалтын орчин нь хараахан бүрдээгүй байгаа шинэ төрлийн санхүүгийн үйлчилгээ эрхлэгчдэд сэндрбоксын орчин нээлттэй.

Сэндрбоксод турших бүтээгдэхүүн, үйлчилгээнд дараах таван үндсэн шалгуурыг тавьдаг. Үүнд:

- ◆ Их Британи улсын нутаг дэвсгэр, зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах зорилготой;
- ◆ Зах зээлд цоо шинээр нэвтэрч буй эсхүл одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлсэн технологийн шийдэл байх;
- ◆ Хэрэглэгчдэд хүргэх үр өгөөжийг нэмэгдүүлсэн буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлыг бууруулж, чанарыг сайжруулсан эсхүл эрсдэлийг бууруулсан байх;
- ◆ Бүтээгдэхүүн, үйлчилгээг бодит зах зээл дээр туршин, хэрэглэгчдэд хүргэхэд бэлэн болгосон, шаардлагатай хөгжүүлэлтийг хийж дуусгасан байх;
- ◆ Сэндрбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээг турших хэрэгцээ, шаардлага үүссэн тохирох зохицуулалтын орчин үүсэж бүрдээгүй байх зэрэг болно.

Их Британи улсын сэндрбокс туршилт нь нэг жил хүртэлх хугацааг хамран үргэлжлэх ба тус улс нь 2016 оны 6 дугаар сараас 2022 оны 8 дугаар сар хүртэл нийт 549 хүсэлт авсан ба 2021 оны 6 дугаар сард ирүүлсэн нийт хүсэлтийн 94 хувь нь амжилттай туршилтад орсон байна. 2021 оны 8 дугаар сар хүртэл сэндрбоксод орох хүсэлтийг жилд 2 удаа хүлээн авч байсан бол тус оны 8 дугаар сараас эхлэн хүсэлтийг хугацаа харгалзахгүйгээр авдаг болсон.

Зураг. Их Британи улсын сэндрбоксоод ирүүлсэн хүсэлтийн тоо, амжилттай туршигдсан хувиар




## МАЛАЙЗ УЛС

Малайз улс нь 2016 онд сэндрбоксо зохицуулалтын орчныг нэвтрүүлсэн анхдагч улсуудын нэг бөгөөд тухайн улсын сэндрбоксо орчин нь санхүүгийн байгууллагууд (бие даан эсвэл Финтек компанитай хамтран ажиллах) болон санхүүгийн үйлчилгээнд технологийн шинэчлэлийг ашигладаг эсвэл ашиглахаар төлөвлөж буй бүх финтек компаниудад нээлттэй байдаг.

Малайзын сэндрбоксо орчинд бүтээгдэхүүн үйлчилгээ турших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ эсхүл зах зээлд санал болгож буй шийдэл нь шинэлэг байх ба дараах шалгуурыг хангасан байна:
  - ◆ санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, аюулгүй байдал, чанарыг сайжруулахад чиглэсэн;
  - ◆ Малайзын санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлсэн; эсхүл
  - ◆ Малайзын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүжилт, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээхэд чиглэсэн.
2. Хүсэлт гаргагч нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинээр нэвтрүүлж буй технологийн шийдлийн ашиг тус, үйл ажиллагаа, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, зах зээлийн эрэлтийн зөрүүг хангах боломжтой эсэхийг харуулах зохих үнэлгээг хийж, холбогдох эрсдэлийг тодорхойлсон.
3. Хүсэлт гаргагч нь сэндрбоксо орчинд туршилт хийх төлбөрийн чадамжтай байна. Үүнд санхүүгийн болон

Зураг. Их Британи улсын сэндрбоксо орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо, төрлөөр



хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээ, шийдлийг сэндрбоксо турших явцад үүсэж болзошгүй эрсдэл, алдагдлыг бууруулах, хянах санхүүгийн чадамжийг харгалзан үзнэ.

4. Өргөдөл гаргагч нь сэндрбоксоос гарсны дараа Малайз улсын зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг гаргах бодит бизнес төлөвлөгөөтэй байх.
5. Сэндрбоксо санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бизнес загвар нь Төв банкны хяналт тавьдаг хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудтай бүрэн эсхүл хэсэгчлэн нийцэхгүй байгаа бол түүнийг тодорхойлсон байх.
6. Финтек компанийг найдвартай, ямарваа нэгэн ёс зүйн зөрчил, гажуудалгүй хүмүүс удирддаг байх зэрэг болно.


Цаашлаад, сэндрбоксо орчинд оролцох өргөдөл болон сэндрбоксоод үйл ажиллагаа явуулж буй оролцогчдоод тавих хязгаарлалтыг авч үзэхдээ дараах шалгуурыг харгалзан үздэг. Үүнд:

- ◆ Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ эсхүл нэвтрүүлж буй технологийн шийдлийн боломжит ашиг тус;
- ◆ Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шийдэлтэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэл ба түүнийг бууруулах арга хэмжээ;
- ◆ Сэндрбоксоод оролцож буй санхүүгийн байгууллага эсвэл финтек компаниудын боловсон хүчний чадавх, туршлага зэрэг болно.

Малайз улсын сэндрбоксын орчинд 2020–2021 онд сэндрбоксад орох нийт 500 хүсэлт ирүүлсэн бөгөөд үүнээс 139 бүтээгдэхүүн үйлчилгээнд сэндрбокс орчинд турших зөвшөөрлийг олгосон. Энэ хугацаанд санхүүгийн туршилтын зах зээл дээр нийт 52.78 тэрбум төгрөг мөнгөн хөрөнгө төвлөрсөн байна. Сэндрбокс орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээний 42 хувийг тагнуулын систем, 3

хувийг блокчейн, 6 хувийг 5G/6G үйлчилгээ, 7 хувийг мэдрэгч технологи, 13 хувийг биотехнологи, 5 хувийг өргөтгөсөн шинжилгээ, 10 хувийг сайжруулсан/ дэвшилтэт материал, 4 хувийг кибер аюулгүй байдлын систем эзэлж байгаа бол үлдсэн 9 хувийг бусад бүтээгдэхүүн үйлчилгээ эзэлж байна.

Зураг. Малайз улсын сэндрбокс орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийн төрлөөр



## ӨМНӨД СОЛОНГОС УЛС

Санхүүгийн салбарт шинээр нэвтэрч буй инновацыг дэмжих, технологийн дэвшлийн өөрчлөлтөд нийцсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэх зорилгоор Өмнөд Солонгос Улсын засгийн газар 2019 онд “Санхүүгийн инновацыг дэмжих акт (Special Act on Support for Financial Innovation)”-ыг батлан сэндрбокс зохицуулалтыг нэвтрүүлж, Солонгосын “Санхүүгийн Үйлчилгээний Хороо (FSC)” нь сэндрбоксыг хэрэгжүүлж байна. Энд Санхүүгийн үйлчилгээний хороо нь сэндрбоксад туршигдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээг сэндрбоксын оролцогч гэх бус “инновацад суурилсан санхүүгийн үйлчилгээ” гэсэн нэршлээр тодорхойлон бүртгэж, хоёр хүртэлх жилийн хугацаанд тухайн үйлчилгээнд хяналт, зохицуулалт тавих замаар сэндрбоксыг хэрэгжүүлдэг.

Өмнөд Солонгос улсын сэндрбокс хөтөлбөрийн үндсэн чиглэл:

- ◆ Нийтийн үнэт зүйлс, сайн сайхан байдлыг хамгаалах: технологийн хөгжлийг дэмжих, төрөлжсөн салбарын өсөлтийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчин, аюулгүй байдлыг хамгаалах;
- ◆ Инновац зохицуулалт: шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй уялдуулан зохицуулалтын орчныг хоцрогдолгүйгээр сайжруулах, шинэчлэх;

- ◆ Хамгаалалтын арга хэрэгсэл: Олон нийт болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах.

**Сэндрбокс хөтөлбөрт хамрагдах байгууллагууд:** Солонгос улсад үйл ажиллагаа явуулдаг “Худалдааны хууль”-ийн дагуу тодорхойлсон компани эсхүл санхүүгийн компаниуд оролцох боломжтой бөгөөд дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан санхүүгийн компанийг инновацад суурилсан санхүүгийн үйлчилгээний зохицуулалтад хамруулах эсэхээ тодорхойлно. Үүнд:

- ◆ Оролцогч компани нь санхүүгийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаагаа дотоодын зах зээлд явуулах эсэх;
- ◆ Оролцогч компанийн санал болгож буй санхүүгийн үйлчилгээ нь зах зээлд аль хэдийн нэвтэрсэн бусад санхүүгийн үйлчилгээтэй харьцуулахад илүү инновацлаг эсэх;
- ◆ Тухайн санхүүгийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлснээр хэрэглэгчдийн хүртэх үр өгөөж нэмэгдэж буй эсэх;
- ◆ Тухайн санхүүгийн үйлчилгээ нь энэхүү хуулиар олгогдсон хөнгөлөлт, чөлөөлөлтгүйгээр санхүүгийн бусад төрлийн зохицуулалтад хамарч болох эсэх эсхүл энэхүү хуулиар олгож буй хөнгөлөлт, чөлөөлөлт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хууль, эрх зүйн аливаа заалтаас бултах, зөрчих нөхцөлийг бүрдүүлж буй эсэх;

- ◆ Оролцогч компани нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бүрэн чадамжтай, мэргэшсэн эсэх;
- ◆ Зах зээлд нэвтрүүлэхээр зорьж буй санхүүгийн үйлчилгээний хамрах цар хүрээ, менежментийн үйл ажиллагаагаар нарийн тодорхойлсон эсэх болон боловсруулсан бизнес төлөвлөгөө нь хэрэгжихүйц эсэх;
- ◆ Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах болон эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөгөө сайн боловсруулан, холбогдох бэлтгэл ажлаа бүрэн хангасан эсэх; Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд эрсдэл учруулж буй эсэх;
- ◆ Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн зохицуулалт, хяналтаас бултах зорилготой, зохицуулалтын орчинд эрсдэл учруулахуйц эсэх.
- ◆ Технологийн болон санхүүгийн салбарт хамгийн багадаа 7 жил удирдах албан тушаал хашсан салбарын оролцогч;
- ◆ Хамгийн багадаа 7 жилийн ажлын туршлагатай хуульч;
- ◆ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлд мэргэшсэн хамгийн багадаа 7 жилийн ажлын туршлагатай мэргэжилтэн;
- ◆ Ерөнхийлөгчийн зарлигаар томилсон бусад.


**Сэндбоксад хамрагдах үйл явц:** Өмнөд Солонгос улсын сэндбокс зохицуулалт нь нийт 5 үе шатыг хамардаг бөгөөд сэндбоксад оролцох хүсэлт бүхий өргөдөл болон холбогдох бусад материалыг санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ. Үүний дараагаар инновацад суурилсан санхүүгийн үйлчилгээний хороо болон “Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC)”, “Санхүүгийн хяналтын хороо (FSS)”-ны төлөөлөл ажлын хэсгийн түвшинд ирүүлсэн материалыг хянан дүгнэж сэндбоксад оролцогчдыг сонгон шалгаруулж сэндбоксын үйл ажиллагааг эхлүүлнэ. Сэндбокс нь хоёр хүртэлх жилийн хугацаатайгаар үргэлжлэх бөгөөд энэ хугацаан дахь үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага, комплайнсын үйл ажиллагаанд нь санхүүгийн зохицуулагч байгууллагаас хяналт тавин ажиллана. Сэндбоксын хугацаа амжилттай үргэлжлэн дууссаны дараагаар санхүүгийн хяналт, зохицуулалтын орчинд хэрэглэгчийн эрх ашиг болон санхүүгийн тогтвортой байдалтай зөрчилдөхгүй байхаар шинэчлэлт, өөрчлөлтийг оруулдаг.

Өнөөдрийн байдлаар Солонгос улсын сэндбоксын хөтөлбөрт 2019 оноос хойш 224 санхүүгийн үйлчилгээ хамрагдсан байна.

**Инновацад суурилсан санхүүгийн үйлчилгээний үнэлгээний хороо:** “Санхүүгийн үйлчилгээний хороо” нь Сэндбоксын оролцогчдын хүсэлтийг хүлээн аван, хянах чиг үүрэг бүхий “Инновацад суурилсан санхүүгийн үйлчилгээний үнэлгээний хороо (цаашид Хороо гэх)”-г байгуулах бөгөөд нэг дарга, 25 хүртэлх тооны гишүүдтэй байна. Хорооны даргын үүргийг “Санхүүгийн үйлчилгээний хороо”-ны дарга гүйцэтгэнэ. Хорооны гишүүдийг мөн “Санхүүгийн үйлчилгээний хороо”-ны дарга томилох бөгөөд санхүүгийн үйлчилгээний хорооны албан хаагчдаас болон дараахаас томилно. Үүнд:

- ◆ Инновацад суурилсан санхүүгийн үйлчилгээнд хамаарах засгийн газрын агентлагийн дэд сайд;
- ◆ Их сургуулийн туслах профессор болон түүнээс дээш зэрэг цолтон, эсхүл санхүүгийн үйлчилгээ, технологийн чиглэлээр мэргэшсэн судалгааны байгууллагад хамгийн багадаа 7 жил ажилсан туршлагатай судлаач;

Зураг. Өмнөд Солонгос улсын сэндбокс орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, төрлөөр



Эдгээр үйлчилгээг төрлөөр нь ангилан харвал дийлэнх хувь буюу 37.4 хувь нь хөрөнгийн зах зээл, хөрөнгийн менежментийн үйл ажиллагаанд, 14.2 хувь нь мөнгөн шилжүүлэг, төлбөрийн үйлчилгээ, 9.8 хувь нь технологид суурилсан даатгалын үйлчилгээ, 7.5 хувь нь мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, хэрэглэгчийг таних үйлчилгээ, 6.7 хувь нь зээлийн үйл ажиллагаанд хамаарч байна.

## УЛС ОРНУУДЫН СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Энэхүү бүлэгт улс орнуудын сэндрокс зохицуулалтын журамдаа тусгасан нийтлэг шалгууруудыг товч танилцуулна.

Сэндрокс зохицуулалтын орчныг нэвтрүүлсэн улс орнууд сэндроксод орох хүсэлт ирүүлсэн компани түүний санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээнд нийтлэг 5 шалгуур тавьж байна. Тухайлбал сэндроксын орчинд турших бүтээгдэхүүн үйлчилгээ нь хэрэглэгчийн зардлыг бууруулж хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлсэн, зах

зээлд нэвтрээгүй эсхүл өмнө нь зах зээлд нэвтэрсэн бүтээгдэхүүн үйлчилгээтэй харьцуулахад шат дамжлага багатай, зардлыг хэмнэсэн байхыг болон тухайн үйлчилгээг заавал сэндроксод турших хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодруулж үздэг бол хүсэлт гаргагчийн хувьд тухайн улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх төдийгүй бүтээгдэхүүн үйлчилгээг турших бэлэн байдлыг хангасан байхыг шаарддаг.

Хүснэгтэд улс орнуудын сэндрокс зохицуулалтад мөрдөгддөг нийтлэг 5 шалгуурыг сонгон судалсан 13 орны хувьд харуулав. Австрали, Хонг Конг, Ямайка, Малайз, Саудын Араб, Сингапур, Шри-Ланка, Тайван, Тайланд, Их британи, Кени болон Нигер улсууд нь бүгд сэндроксод санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээндээ хэрэглэгчийн үр өгөөжийн нэмэгдүүлэхэд чиглэсэн байх, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зах зээлд шинэлэг байх гэсэн 2 шалгуурыг тавьдаг бол үлдсэн 3 шалгуурыг улс орнууд өөрсдийн нөхцөл байдал, онцлогт тохируулан тавьсан болох нь ажиглагдаж байна.

Хүснэгт. Улс орнуудын сэндрокс зохицуулалтад мөрдөгддөг нийтлэг шалгуурууд

Улс орнууд	Хэрэглэгчийн үр өгөөжийн нэмэгдүүлэх	Сэндроксод оролцох хэрэгцээ шаардлага байгаа эсэх	Туршихад бэлэн эсэх	Зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ мөн эсэх	Тухайн улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх
Австрали	+	+	+	+	-
Хонг Конг	+	-	+	+	-
Ямайка	+	+	+	+	-
Малайз	+	+	+	+	-
Саудын араб	+	+	+	+	-
Сингапур	+	+	+	+	-
Шри-Ланка	+	+	+	+	-
Тайвань	+	+	-	+	+
Тайланд	+	+	+	+	+
Их британи	+	-	+	+	-
Кени	+	+	+	+	+
Нигер	+	+	-	+	-

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгааны ажлаар сэндрбокс зохицуулалтын олон улсын өнөөгийн байдал болон 13 орны сэндрбокс зохицуулалтын журмын төсөлтэй танилцан Монгол улсын сэндрбоксын орчны журамтай харьцуулан судаллаа.

Сонгогдсон 13 орны хувьд сэндрбоксын хүсэлт хүлээн авах хугацаа, хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээ, сэндрбоксоос гаргах нөхцөлүүдийг тодорхой зааж өгч зөрчсөн тохиолдолд авах хариу арга хэмжээг нарийн тодорхойлсон байна. Их британи улсын хувьд жилд 2 удаа хүсэлт хүлээн авдаг байсан бол 2021 оны 8 сард хүсэлт хүлээн авах хугацааг тасралтгүй болгон өөрчилсөн. Энэ нь бизнесийн байгууллагуудын зардлыг бууруулах, зах зээлд нэвтэрч буй бүтээгдэхүүний шинэ тоог нэмэгдүүлэх, шинэ

бүтээгдэхүүн нэвтрүүлэх хугацааг хурдасгахтай холбоотой. Мөн Их Британи, Сингапур, Австрали зэрэг улсууд сэндрбокс зохицуулалтаа хөгжүүлэн нэмэлтээр дижитал сэндрбокс, экспресс сэндрбокс, сэндрбокс плас зэрэг нэмэлт төрлийн сэндрбокс зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

Улс орнуудад хэрэгжүүлж буй сэндрбокс зохицуулалтыг харьцуулахад манай улсын сэндрбоксын журамд заасан хүсэлт хүлээж авах хугацаа, хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээ, мэдээллийн аюулгүй байдал, сэндрбоксын тайлан, тайлангийн агуулга түүнийг хүлээн авах хугацаа болон сэндрбоксоос хугацаанаас өмнө гаргах нөхцөлүүдийн зарим заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулан олон улсын сайн туршлага стандартыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

[Sanhuugiin SUDALGAANII EMHETGEL 2022 final.pdf \(frc.mn\)](#)  
холбоосоор дэлгэрэнгүй судалгаатай танилцана уу.





## СЭНДБОКСОД ОРОХ ХҮСЭЛТ ГАРГАХ



Хүсэлт гаргагч нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн, Сэндбоксын албанд хүргүүлнэ.

**1** Сэндбоксад орох хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг;

**2** “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргасан өргөдөл;

**3** “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 4.3-т заасны дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөө;

**4** Сэндбоксад оролцох бүртгэлийн хураамжийг төлсөн тухай төлбөрийн баримт;

**5** Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдүүд тус хуулийн 14.4-т заасан дотоод хяналтын хөтөлбөр;

**6** Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д


хамааралгүй этгээдүүд бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх арга хэлбэр болон хэрэглэгчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн журам.



Та сэндбокс орчны тухай мэдээлэл авахыг хүсвэл дээрх холбоос руу хандаарай.



## СЭНДБОКСЫН ЕРӨНХИЙ ПРОЦЕСС:



## ЯРИЛЦЛАГА

### САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ СЭНДБОКСЫН ОРЧИНД ЦАГ АЛДАХГҮЙ ТУРШИХ НЬ

*Энэ удаагийн ярилцлагаар Банк бус санхүүгийн байгууллагуудын репо хэлцлийн үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд туршиж буй Мони маркет фанд ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батжаргалтай ярилцлаа.*



**Сайн байна уу?, Танд энэ өдрийн мэндийг хүргэе! Танай байгууллага Сэндбоксын зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулаад жил гаруй хугацаа өнгөрч байна. Сэндбоксын оролцогчийн хувьд энэ тухай ойлголтыг энгийнээр тайлбарлана уу.**

Сэндбокс /sandbox/ хэмээх үгийг Монголоор махчлан орчуулбал “Элсэн хайрцаг” гэж ойлгож болохоор, гэхдээ энэ нь өргөн агуулгаараа технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд (хүнээр зүйрлэвэл) өлгийдөж авах, бойжуулах, бие даан амьдрах чадвар суулгах бүхий л мөчлөгийг үе шатуудыг тодорхой цаг хугацаанд, тодорхой хязгаарлалтын хүрээнд туршиж, цаашид хууль эрх зүйн орчин, журам зааварт өөрчлөлт оруулах, цаашлаад албан ёсны зохицуулалтын орчин бүрдүүлэх цогц арга хэмжээ юм.

Олон улсад Сэндбоксын зохицуулалтын орчин нь анх Их Британи улсад нэвтэрсэн бол өдгөө дэлхийн 70 гаруй оронд энэ зохицуулалтын хэлбэр нэвтрээд байна. Манай улсын хувьд 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал нарын хамтарсан тушаалаар Сэндбокс зохицуулалтын орчны журам батлагдаж бүтээгдэхүүн үйлчилгээгээ бодит орчинд турших боломж бүрдсэн.

Энэхүү сэндбоксын орчинд олон төслүүд хамрагдах санал өгснөөс Сэндбоксын зохицуулалтын тавигдах шаардлага, бизнес төлөвлөгөө, цаашид манай улсын санхүүгийн системийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зэрэг олон шаардлагыг хангаж “Мобифинанс ББСБ” ХХК-ийн Монпэй цахим мөнгөнд суурилсан дижитал бонд болон манай байгууллагын Мони маркет вэб системээр дамжуулан репо хэлцлийн хүсэлт хүлээн авах, хэлцлийн дагуу худалдах, худалдан авах үйлчилгээ маань Сэндбоксын зохицуулалтын орчинд туршигдах анхдагч төслүүд болж чадсан билээ.

#### **Танай төсөл юугаараа онцлог болоод энэ зохицуулалтын орчинд орсон бэ?**

“Мони Маркет Фанд” ХХК-ийн хувьд 2021 онд байгуулагдсан шинэ байгууллага боловч банк санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай хамт олон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын богино хугацааны мөнгөн хөрөнгийн хэрэгцээтэй болон илүүдэлтэй талуудыг нэгдсэн платформын тусламжтай холбож, санхүүгийн хэрэгцээг хангах үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд ББСБ-уудын зээлийн багцад зохицуулагч байгууллагаас өөр байгууллага тогтмол түүврийн аргаар тулган баталгаажуулалт хийж, зээлийн чанар болон санхүүгийн тайлагналыг сайжруулах замаар салбарын хөгжилд шинэ ахиц дэвшил гаргах зэрэг ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Их Хурлаас баталсан Зээлийн хүүг

бууруулах стратегийн зорилттой нийцэж байгаагаараа онцлогтой.


Манай платформыг ашиглан репо нөхцөлөөр хэвийн зээлийн багцаа худалдах, тодорхой хугацааны дараа буцаан худалдан авах, богино хугацааны зээл олгох, авах боломжтой. Энэ үйл ажиллагааны онцлог нь хэвийн зээлийг худалдаж авах, зээл олгохдоо зээлдэгч, зээлдүүлэгч ББСБ-уудаас ирүүлбэл зохих баримт, бичгүүдэд үндэслэн “Мони маркет фанд” ХХК-ийн эрсдэлийн багаас эрсдэлийн дүгнэлт гаргаж, шаардлага хангасан зээлдэгч, зээлдүүлэгч нартай хамтран ажиллах гэрээ байгуулан платформд нэвтрэх эрхийг нээнэ. Ингэснээр мөнгөний захын Репо зээлийн арилжаанд оролцох боломжтой болно. Репо зээлийн хугацаа нь 7, 14, 28, 84 гэсэн хоногтой бөгөөд зээлийн хэмжээний хувьд Сэндбокс зохицуулалтын орчноос тогтоож өгсөн тодорхой хязгаарлалтын хүрээнд “Мони маркет фанд” ХХК-аас тооцдог аргачлалаар хэлцлийн дүнг тооцдог. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бид нийт 41 ББСБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, нийт 471 репо зээлийн арилжааг зохион байгуулсан байна.

### **Та сэндбоксын оролцогч байгууллагын хувьд Сэндбоксын орчны ач холбогдлын талаар тайлбарлана уу?**

Дэлхий нийтэд технологийн хөгжилтэй уялдан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнүүд өдөр бүр нэмэгдэж буй энэ үед иргэд, аж ахуй нэгжүүдийг болзошгүй

эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүжилтийн өртгийг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг алдахгүй туршин зах зээлд нэвтрүүлэх боломж олгож байгаагаараа Сэндбокс зохицуулалтын орчин нь маш чухал ач холбогдолтой байгаа нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд дахь хамтын ажиллагаанаас харагдаж байна.

Энэ жилийн хувьд манай төсөл дахин сэндбоксын туршилтын хугацаагаа сунгуулсан ба мөн шинэ 3 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбокс орчинд туршигдах болсон нь Сэндбоксын үйл ажиллагаа өргөжих байгаагийн илрэл юм. Мөн цаашлаад шинээр туршигдах төслүүдийг судлах, бусад улс орнуудтай харьцуулах, дүн шинжилгээ хийж, холбогдох эрх зүйн орчныг хамтран боловсруулах, зөвлөлийн гишүүдийг шийдвэр гаргахад туслалцаа үзүүлэх зорилготой Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дор Сэндбоксын албыг байгуулсан нь шинэ бүтээгдэхүүнүүдийг бойжуулах олон улсын төвшинд санхүүгийн зохицуулагч байгууллага нь хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллах жишиг болохуйц ач холбогдолтой юм.



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### 2023 ОНД ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ 1.7 ХУВИАР ӨСНӨ.




Дэлхийн банк 2023 онд дэлхийн эдийн засгийг 1.7 хувиар өснө гэж таамаглал дэвшүүлсэн нь өнгөрсөн онд танилцуулж байсан таамаглалаас 1.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийн тайланд хөгжингүй улс орнуудын эдийн засгийн өсөлтийн таамаглал дийлэнх нь буурсан байдалтай байв.

Тухайлбал, 2023 онд АНУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2.4–0.5 хувьд, БНХАУ-ын өсөлтийг 5.2–4.3 хувьд, Японы өсөлтийг 1.3–1.0 хувьд, Европ, Төв Азийн өсөлтийг 1.5–1.0 хувьд хүргэж тус тус бууруулсан байна.

Шинжээчид 2022 оныг дараах байдлаар таамаглаж байжээ:



Meme coin – таамаглал дээр суурилдаг, онлайн худалдаанд ашиглагддаг.

[www.simplilearn.com](http://www.simplilearn.com)

Мөн дэлхийн эдийн засгийн байдал эмзэг байгаа тул инфляц хүлээгдэж байснаас өндөр гарах, түүнийг хянахын тулд хүүг огцом өсгөх, Ковид-19-ийн халдварын тохиолдол дахин нэмэгдэх, геополитикийн хурцадмал байдал даамжрах зэрэг шинэ таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд уналтад орж болзошгүй гэдгийг тайланд анхааруулжээ.

[www.worldbank.org](http://www.worldbank.org)

### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД 2023 ОНД КРИПТОВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ ӨСНӨ ГЭСЭН ӨӨДРӨГ ТААМАГЛАЛТАЙ БАЙНА.

Криптовалют ойрын ирээдүйд урьдчилан тааварлашгүйгээр өсөх үү, эсвэл тогтворгүй байх уу гэж олон хөрөнгө оруулагчид эргэлзэж байгаагаас дийлэнх нь өснө гэсэн өөдрөг таамаглалыг дэвшүүлсэн.


Coinbase 2021 оны 4 дүгээр сард олон нийтэд нээлттэй анхны томоохон крипто компани болж, 10 дугаар сард биткойнтой холбоотой АНУ-ын анхны бирж арилжааны сан байгуулагдсан. Дижитал валют 2021 он гарснаас хойш 70.0 хувь орчмоор өссөн нь криптогийн зах зээлийг нийтдээ 2 их наяд долларын үнэд хүргэсэн.

# ОЛОН УЛСЫН КРИПТОВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Bitcoin /^BTC-USD/


**22,774.71** -73.96 (-0.32%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Ethereum /^ETH-USD/


**1,639.39** +9.75 (+0.60%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

BNB /^BNB-USD/


**305.43** +4.19 (+1.39%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Solana (^SOL-USD)

**24.58** -0.51 (-2.04%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia